

## “Монноос” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайлан

Илтгэгч: Гүйцэтгэх захирал  
Х.Эрдэнэбаяр

“Монноос” ХК нь 2018 онд үндсэн үйл ажиллагаа явуулж чадаагүй боловч ноос угаах үйлдвэрлэлээ сэргээх бэлтгэл ажил болох засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнээс гадна сул боломжтой ноосны агуулахууд, дулаан, цахилгаан, цэвэр, бохир усны шугам бүхий үйлдвэрлэл, оффиссын байрнууд болон гадаах чөлөөтэй зам талбай зэргийг түрээслэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн явууллаа.

### 1. “Монноос” ХК-ийн 2018 оны үйл ажиллагаа

1.1 Нийт 14 аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй түрээсийн гэрээ байгуулж ажилласан байна.

1.2 Түрээсийн үйл ажиллагааны орлого, зарлагыг 2017 онтой харьцуулан үзүүлбэл.

| № | Үзүүлэлт  | 2017 он   | 2018 он  | Зөрүү   |        |
|---|-----------|-----------|----------|---------|--------|
|   |           |           |          | төгрөг  | хувиар |
| 1 | Орлого    | 113,883.5 | 112445,5 | -1438,6 | -1,2%  |
| 2 | Зарлага   | 112,118.8 | 110990,9 | -1127,9 | -1,09% |
| 3 | Нийт ашиг | 1764,7    | 1454,6   | -311,1  | -0,11% |

1.3 Мал эмнэлэгийн ихэнх хэсэг болон зоорины зориулалт бүхий хүйтэн байр, оффисын 50м<sup>2</sup> дулаан байр зэргийг түрээслэж чадаагүй байна.

1.4 “Монноос” ХК нь түрээслэгч 14 компани, хувь хүнтэй дулаан, цахилгаан, ус, хог тээвэрлэлтийн болон түрээсийн төлбөр тооцоог хийж сар бүр төлбөрийг нэхэмжлэн хугацаанд нь хураан авч байлаа.

1.5 Өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: а) 2 давхар оффисын хэсэгт 25-ын изгон 3ш, 20-ын изгон 10ш, отвод 4 ширхэгийг шинээр солисон байна.

б) Дулааны узельд ялтсан бойлорыг цэвэрлэж угаасан. Дулааны узелын хуучирсан шугам хоолойнуудыг сэргээж засварлав.

в) КНС-д нөөц насос шинээр авч тавив.

г) Цахилгаан утаснуудын гадна хамгаалалтуудыг хийж засварлав.

1.6 Цэвэр усны тоолуур, дулааны узелын даралтын манометр болон хэмжих хэрэгслүүдийг шинэчлэн баталгаажуулав.

1.7 Бохирын худагнуудыг цэвэрлэж хогийг нь зөөж асгуулав. Үүнд 2596,0 мянган төгрөг зарцуулав.

1.8 2018 онд “Монноос” ХК нь 6 байршил бүхий эзэмшил газруудын гэрээ гэрчилгээнүүдийг 15 жилээр шинэчлэн сунгуулав.

1.9 “Монноос” ХК нь 6 байршил бүхий газруудын 2018 оны газрын төлбөр болох 21,7 сая төгрөгийг “Ариг гал” ХК-тай хийх зээлийн гэрээний дагуу хоорондын тооцоогоор шийдвэрлэж төлөв.

1.10 УБДС ТӨХК-д төлөх ялтсан бойлоруудын төлбөрийн үлдэгдэлийг төлж барагдуулав. /Том бойлор – 70,0 сая, жижиг бойлор -40,0 сая төгрөг нийт 110,0 сая төгрөгийн өр байсан болно.

1.11 Түрээслэгч аж ахуйн нэгжүүдэд “Монноос” ХК-ийн эзэмшлийн газрыг хуваарилан өгч цэвэрлэгээг хийлгүүлж ажилласан.

1.12 Сар бүр ХУД-ын ТҮК-ээр компанийн хогийн цэгт хуримтлагдсан хогийг ачуулж байсан болно.

1.13 “АПУ” ХК-тай хийсэн тохиролцооны дагуу “Монноос” ХК-ийн эзэмшил газарт буй засмал зам болон ноосны агуулахын баруун тал дах хогийн цэг бүхий тадбай зэргийн түрээсийн төлбөрөөс (сард .....6.25.0.118 төгрөгийн түрээс) суутган тооцож “АПУ”ХК-ын барьсан төмөр хашааг /16 сая төгрөгийн өртөг бүхий/ 2019 оны 1-р сард “Монноос” ХК-ийн өмчлөлд авах эрх зүй бүрдлээ. Ингэснээр “Монноос” ХК-ийн 7000 м<sup>2</sup> гаруй газар өөрийн өмчийн төмөр хашаагаар хамгаалагдсан болно.

1.14 “Монноос” ХК нь 1800 м<sup>2</sup> талбай бүхий хүйтэн агуулахын түрээсийн төлбөрт тооцож уг агуулахын дээврийн засварын төлбөрийг (нийт .....46,0 сая төгрөг) хийж дуусгасан бөгөөд 2018 оны 9-р сараас эхлэн уг 1800 м<sup>2</sup> талбайд үйл ажиллагаа явуулахаар тоног төхөөрөмжөө суурьлуулсан. “Блю скай хавтан” ХХК-аас түрээсийн төлбөрөө бодитоор авах боломж бүрдлээ. 1800 м<sup>2</sup> \*2000 төгрөг = 3,6 сая төгрөгийн түрээсийн орлого сар бүр авах болно.

## **2. Ноос угаах үйлдвэрлэлийг сэргээх бэлтгэл ажлын талаар**

Сул зогсолтонд ороод 17 жил болсон ноос угаах үйлдвэрлэлийг сэргээн босгох Сайжруулалтын төлөвлөгөө гаргаж ажиллав. Энэхүү Сайжруулалтын төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг “Ариг гал” ХК болон “Тэнгэр зууч” ХХК-уудаас авсан 110,0 сая төгрөгийн зээлийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

2.1 Ноос угаах шугамын 5 ширхэг угаах онгоц, хатаах машин, пресс машин гэх мэт тоног төхөөрөмжийн иж бүрэн засварыг хийв.

2.2 Ноос угаах шугамын цахилгаан моторууд, цахилгааны щит, цахилгааны утаснуудын холболт бусад шаардлагатай цахилгааны монтажыг шинэчлэн хийлгэв.

2.3 Бохирын шугамын дарагдсан худгуудыг ухаж гарган засварлан ажилд бэлэн болгов.

2.4 Ноос угаах шугамыг цэвэр усаар хангах шугам сүлжээг засварлуулав.

2.5 Ноос угаах үйлдвэрлэлд ажиллах боловсон хүчнийг бүрдүүлсэн болно.

## **3. Найман давхар оффисын барилгын талаар**

3.1 “Монноос” ХК-ийн 8 давхар оффисын барилгад орон сууц, цэцэрлэг болох төслийн хүрээнд уг объектын дээвэр, барилга доторхи байгууламжийн өөрчлөлт, гадна болон доторхи инженерийн, шугам сүлжээний засвар, барилгын дотор засварын ажлын эхний шат болох дээврийн засварыг 11,151,0 мянган төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгүүлээ.

#### 4. “Монноос” ХК-ийн 2019 оны хийгдэх ажлууд

4.1 “Ариг гал” ХК-аас цахилгааны тэжээл авч ажиллах ажлын төсөл, төсвийг гаргаж хэрэгжүүлэх. Ингэснээр цахилгааны хангалтыг “Нолго” ХХК-аар дамжуулан өндөр тариф, зардлаар авч алдагдалд орж байсныг таслан зогсооно.

4.2 Угаах үйлдвэрлэлд шаардлагатай уурын шугамыг шинэчлэн засварлах.

4.3 Ноос угаах үйлдвэрлэлийг явуулахад шаардлагатай дулаан, уур усны гэрээнүүдийг байгуулах

4.4 Бохирын шугам, КНС-ийн үйл ажиллагааг найдвартай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд холбогдох засварыг хийх

4.5 Бохирын шугамын ачааллыг нэмэгдүүлж буй хөрсний усны асуудлыг шийдвэрлүүлэх

4.6 Өвлийн бэлтгэл ажлын хүрээнд хуучирсан шугам хоолойг солих, бохирын шугам хөлдөхөөс хамгаалдаг утас /кабель/-ыг тавиулах

4.7 Дулааны ялтсан бойлорын моторын ажлын дугуйг шинэчлэн солих

4.8 Нисэх дэх эзэмшил газрын ашиглалтыг шийдвэрлэх

4.9 Харуулын хуучин байрыг засварлан ажилд оруулах. /дулаан, цахилгаан, гэх мэт/

4.10 Хогийн цэгийн гадна төмөр хашааг барих

4.11 8 давхар оффисын байрыг орон сууц, цэцэрлэг болгож засварлах ажлыг хийлгэх үйл ажиллагааг эхлүүлэх

4.12 Ноос угаах шугам дээр бохир ноолуур угааж хамтран ажилладаг компаниар самнуулан самнасан ноолуурыг зах зээлд гаргах төслийг боловсруулан хэрэгжүүлэх